

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Хэлэлцүүлгийн чиглүүлэгч: ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн
Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор Р.Төрдалай

Та бүхэндээ оройн мэнд хүргэе. Бүтэн өдрийн турш үргэлжилсэн “Олон улс судлал 2020: Монголын Хятад судлал” эрдэм шинжилгээний хурал маань хөтөлбөрт тусгагдсан бүх илтгэлээ хэлэлцүүлж дууслаа. Илтгэлээ хэлэлцүүлсэн нийт эрдэмтэн судлаачид, цаг заваа гарган оролцсон бүх хүмүүст талархал илэрхийлье.

Ингээд хэлэлцүүлгээ эхлүүлье. Эхлээд асуулт, хариултын хэсэг явагдана. Илтгэлээс асуулт асуух эрдэмтэн судлаачид байна уу?

Асуулт, хариулт

Доктор Н.Алтантөгс: Доктор Н.Отгонсайханаас асуулт асууя. 1. Монголын нүүрсийг ямар ямар гол компани, үйлдвэрүүд худалдан авч байна вэ? 2. Тэдний Монголоос нүүрс авах импортын гол шийдвэрийг хэн гаргаж байна вэ? 3. Худалдан авагч талд Хятадын төрийн өмчит компани хэр их байдаг вэ?

Доктор Н.Отгонсайхан: Доктор Н.Алтантөгсийн асуултад хариулъя. Хамгийн гол худалдан авагч нь цахилгаан станцууд, гангийн үйлвэрүүд, барилгын, химийн үйлдвэрүүд. Энэ дотор хамгийн чухал худалдан авагч нь цахилгаан станцууд. 2009, 2010 оноос өмнө нүүрсний 60-70 хувийг цахилгаан станцууд ашигласан гэсэн тооцоо байдаг. Түүнээс хойш буурч байгаа дүр зураг харагдаж байна билээ. 2008 оны байдлаар Хятад 39,1 тэрбумын хэрэглээ байна. Түүний 21 орчим тэрбум нь цахилгаан станцууд ашигладаг. Гэхдээ цаашдын төлөв байдлыг харвал энэ хэмжээ буурах төлөвтэй байна. Учир нь сэргээгдэх эрчим хүчийг илүү ашиглах тал руугаа явж байна. Мөн бохирдлыг бууруулах чиглэлд анхаарч байгаа учраас нүүрсний хэрэглээ буурна гэж үзэж байна. Хотжилт, барилгажилттай холбоотойгоор гангийн үйлдвэрийн эрэлт сүүлийн 3 жилд тогтмол байсан. Барилгын үйлдвэр ч гэсэн ерөнхийдөө тогтмол. Химийн үйлдвэрт мөн адил эрэлт тогтмол байна. Цахилгаан станцын нүүрсний эрэлт 2018 онд нэлээд өссөн боловч ирээдүйд буурна гэсэн төлөв ажиглагдаж байсан. Үндсэндээ Засгийн газраас гол шийдвэрийг гаргадаг. Тухайлбал манай нүүрсийг хэрэглэж байгаа гол муж нь Хэбэй муж. Энэ муж нийт гангийн үйлдвэрлэлийн 11 орчим хувийг үйлдвэрлэдэг. Хамгийн олон гангийн үйлдвэртэй муж юм. Өмнө нь энэ мужид 64 гангийн үйлдвэр байсан. 2020 онд 30 болгосон. 2025 онд 25 болгоно гэсэн шийдвэрийг Засгийн газраас нь гаргасан байна билээ. Ер нь цаашид манай нүүрсний экспортын асуудалд хүндрэлтэй нөхцөл үүсэж болзошгүй юм. Гуравдугаар асуултын хувьд

төрийн болон төрийн бус гэсэн байдлаар нарийн судалж үзсэнгүй. Ер нь судалгаа хийж байхад голдуу төрийн өмчит компани худалдан авч байгаа дүр зураг харагдаж байгаа. Сүүлийн үед Хятадын төрийн өмчит компаниуд нэгдэн нийлж, цар хүрээ нь томрох явдал нэлээд ажиглагдаж байна. Тухайлбал “Эрчим хүчний үндэсний хөрөнгө оруулалтын корпораци” гээд хоёр том эрчим хүчний олборлогч, үйлдвэрлэгч компаниудын нэгдэл байна. Энэ нь төрийн өмчит корпораци юм. Гол эх үүсвэрийн 70-80 хувийг нүүрс гэж үздэг. Гэхдээ цаашид нүүрсний хэрэглээг бууруулж, сэргээгдэх эрчим хүч рүү орно гэсэн ирээдүйн төлөв байдлын судалгааг би уншиж байсан. Хувийн өмчит компани байгаа хэдий ч төрийн өмчит компанийн хажууд маш жижиг байдаг.

Доктор Н.Алтантөгс: 1. Монгол дахь Хятад судлалын ахисан түвшний боловсон хүчин бэлтгэж буй өнөөгийн байдал ямар байгаа вэ?

2. БНХАУ-д магистр, докторын түвшинд суралцаж байгаа оюутнуудын судалгааны сэдвийн талаар судалгаа байна уу? Аль шинжлэх ухааны салбарт түлхүү суралцаж байна вэ?

Доктор Г.Цогзолмаа: Нэгдүгээр асуултын тухайд миний бодлоор ахисан түвшний сургалт, тэр дундаа магистр, докторын сургалт тодорхой хэмжээнд явагдаж ирсэн. Учир нь манайд үндэсний боловсон хүчнүүд маш сайн бэлтгэгдсэн. Доктор, профессоруудыг дагасан дэгүүд байдаг. Сургууль бүр өөр өөрийн онцлогтой. Энэ чиглэлээр манай улс тодорхой түвшинд маш сайн хөгжиж байгаа гэж боддог. Гэвч бид ганцхан зүйл дээр нэгдэх шаардлагатай. Миний илтгэлийн сүүлийн хэсэгт зэрэг хамгаалсан оюутнуудын сэдэв жагсаалтаараа байгаа. Түүнийг үзэж болно. Эндээс харахад бид судалгааны байгууллагууд хамтраад судалгааны санал болгох сэдвүүд эсвэл сэдвийн давхардал, төлөвлөгөөт сэдэв гэх мэт асуудлуудаар ойр ойрхон уулзаж, ярилцаж байх шаардлагатай мэт санагддаг. Сургууль тус бүрээр ийм ажил хийгдэж байгаа хэдий ч улсын хэмжээнд энэ асуудал яригдаж чаддаггүй. Хоёрдугаарт, 2019 онд Монгол, Хятадын 70 жилийн ойгоор Хятад судлалын чиглэлээр эрдэм шинжилгээний ажил хийдэг бүх байгууллага материалаа орчуулсан. Энэ нь соёлын сайт дээр тавигдсан гэж байсан. Боломж байвал бид үүнийг монгол, хятад хоёр хэл дээр гаргавал маш олон, тодорхой материал тэнд байгаа гэж үзэж байгаа. Жишээ нь би МУБИС -ийн Хятад судлалын хөгжил, түүхийг тухайн хугацаанд ажилласан бүх эрдэмтдийн бүх материалыг судалж гаргасан. Үүнийг цаашид боть болгоод гаргачих юм бол илүү хэрэгтэй юм болов уу гэж бодож байна. Манай сургуулиас тэргүүлэх чиглэлээ 10, 15 жилээр гаргадаг. Хоосон орон зай юу байна гэж. Манайх гэхэд 5 мэргэжилтэй. Үүнд 2002-2017, 30 жил, 40 жилээр гаргадаг. Яг үүнтэй адилаар бид хоёр орны Хятад судлалын чиглэлээр бүтээл гаргавал зүгээр юм шиг санагддаг. Нөгөө талаар бас ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн болон бусад хүрээлэнгийн сэтгүүлүүдэд гаргасан бүтээлийн жагсаалтууд шиг хоёр орны судалгааны чиглэлээр гарсан бүтээлийн жагсаалт гэж гаргавал бас их зүгээр санагддаг. Хувь судлаачийн хувьд Маналжав доктор бид хоёр БНХАУ-д хэвлэгдсэн “Монголын нууц товчоон”-ы чиглэлийн магистр, докторын нэг сэдэвт бүтээл, эрдэм шинжилгээний бүх

өгүүлийн санг 1995 оноос хойш хийж байгаа. Жил болгон бүх гарсан бүтээлийг албан ёсны сайтуудаас авч нэгтгэн сан бүрдүүлж байгаа. Энэ мэтээр судлаачид сонирхсон сэдвээрээ судалгаа хийх боломжтой юм.

2. Манай сургуулийн хувьд боловсрол судлал, хэл шижлэлийн чиглэлээр Хятадад хамгаалсан оюутнуудын сэдвийн жагсаалт бий. Сая бид жишээ болгоод боловсрол судлал, гадаад хэл заах аргын чиглэлээрх жагсаалтыг гаргасан. Нэг асуудал нь юу вэ гэхээр ихэнх сэдвүүд нь 1995 оноос хойш цахим бүртгэлд орсон сэдвүүдийг багтаасан. Түүнээс өмнөх үеийн цахим бүртгэлд ороогүй сэдвүүдийн талаарх мэдээллийг тухайн сургууль дээр нь очих эсвэл архивд сууж судлахаас өөр аргагүй болно. Тэгэхээр энд хоосон орой зай үлдэж байгаа учраас бид сургуулиудтай гэрээ хийх юм уу эсвэл өөр шугамаар авах боломжтой байх гэж бодож байна. Судалгааны чиглэлийн хувьд нэг шинэ чиг хандлага харагдаад байгаа. 2005 оноос хойш хятад хэл заах аргын чиглэлээр маш олон магистрын дипломын ажлууд бичигдэж байна. Энэ нь гадаад хэлний үндсэн чадвар буюу хятад хэлний ярих, сонсох, унших, бичих, ханзны чадварууд гэсэн практик чиглэлийн сэдвүүд голлож байна. Энэ нь бид цаашид судалгааг аль чиглэлд явуулах нь зүйтэй вэ гэдгийг бодолцох хэрэгтэйг харуулж байна. Онолын судалгаа хийх эсвэл хэрэглэний чиглэлээр ямар судалгаа хийх вэ гэдэг дээр онцгой анхаарахгүй бол болохгүй. Энэ сэдэв яагаад давамгайлж байгаа нь их учиртай. Өмнө нь магистрантурыг гурван жилийн хугацаагаар Засгийн газрын тэтгэлэгээр сургадаг байсан бол сүүлийн жилүүдэд 对外汉语教学 буюу хятад хэлний заан сургалтын 2 жилийн тэтгэлгүүд огцом нэмэгдсэнтэй холбоотой.

Доктор Д.Шүрхүү: Н.Ганбат доктороос асуулт байна. БНХАУ-аас санхүүжүүлж байгаа хамтарсан төслийн үр дүнг эзэмших эрх 50, 50 хувь байж чадаж байна уу?

Доктор Н.Ганбат: Гэрээг эх хувиар харах боломж бол байхгүй юм билээ. Хоёр улсын Шинжлэх Ухааны Академийн хамтын ажиллагааны хүрээнд нэг жилийн хугацаатай явагдсан бидний судалгааны ажлын хүрээнд ШУА-ийн гадаад харилцааны хэлтсээс хамтран ажиллаж байгаа хүрээлэнгүүдийн талаар мэдээлэл авах, мөн хүрээлэнгүүд рүү хандаж байгаа. Академич Д.Рэгдэл гуайн нэрээр албан бичгүүд хүргүүлж байсан. Энэ бүгдээс харахад 50, 50 хувиар эзэмшинэ гэдэг ч юмуу ийм зүйл бол бичигдсэн байдаг. Заримдаа энэ нь тэр болгон мөрдөгддөггүй юм болов уу гэж би хувьдаа харж байна.

Доктор Н.Отгонсайхан: Доктор Н.Ганбат, Н.Алтантөгс нараас асууя. Манай шинжлэх ухааны гадаад хамтын ажиллагаанд Хятадын эзлэх жин ямар хэмжээнд байгаа юм бол? Бусдаас онцлох шинж нь юу вэ?

Доктор Н.Ганбат: Маш товч хариулбал зонхилсон гэж хэлж болох юм. Технологи, инновац талдаа хэрэглээ рүү чиглэсэн судалгаан дээр голлож байх шиг байна. Уул уурхай руу чиглэсэн, Монголын байгалийн баялаг, эрдэс баялгийн судалгаа хийх гэдэг ч юмуу энэ чиглэл рүү илүү түлхүү судалгаа хийж байгаа дүр төрх ажиглагдаж байна.

Доктор М.Золзаяа: Г.Цогзолмаа докторын илтгэлтэй холбоогүй ч байж

магадгүй. Улс төрийн намуудын захиалгаар ч юмуу, тэдний хөрөнгөөр БНХАУ-д магистр, докторт сургадаг талаар мэдээлэл байна уу? Төрийн бус байгууллагуудыг яаж дэмждэг юм бол? Хятад дахь оюутны холбоог улс төрийн намын дэргэдэх төрийн бус байгууллага дэмжиж ажиллаж байгаа талаар мэдээлэл би харж байсан. Энэ талаар ажиглалт байна уу? Хятадад боловсон хүчин бэлдэх хоёр орны боловсролын хамтын ажиллагаатай холбоотой, бас бодууштай ч юмуу тийм асуудал гэж би бодоод байна л даа.

Доктор Г.Цогзолмаа: Энэ талаар би сайн мэдэхгүй байна. Н.Ганбат докторын хэлсэнчлэн энэ талаар мэдээлэл, гэрээ, материал олоход маш хэцүү. Бид бол сурвалжуудаа гарсан мэдээ, албан ёсны сайтуудаас материалуудаа авч байгаа. Улс төрийн намуудын оролцоо, оролцдог эсэх талаар хэлж мэдэхгүй байна. Харин засгийн газрын тэтгэлгүүд бол хоёр улсын хамтын ажиллагааны хүрээнд, хөрш орнуудын хамтын ажиллагааны хүрээнд явагдаж байгаа тэтгэлгүүд. Гол нь бид энэ тэтгэлгийг үр ашигтай зарцуулах нь бидний хамгийн гол зорилго гэж бодож байна. Оюутны холбооны талаар бас сайн хэлж мэдэхгүй байна. Надад тодорхой ойлголт алга. Улс төрийн талаар ойлголт тун муутай. Хүлцэл өчье.

Доктор Р.Төрдалай: Эрдэмтдээс асуулт хариулт авч дууслаа. Одоо санал хэлэх хэсэгтээ орёё.

Санал

Доктор Д.Золбоо: Өнөөдрийн хуралд 22 хүн идэвхтэйгээр оролцож байна. Мэргэжлийн хүмүүс хэрэгтэй мэдээллүүдээ хуваалцаж чадаж байгаагийн илрэл гэж бодож байна. Бид 1 дүгээр сард багтаагаад хурлын илтгэлийг эмхэтгэл болгож гаргахаар төлөвлөсөн. Тийм учраас энд байгаа илтгэгч нар болон ханан итгэл өгөхөөр нэрсээ ирүүлсэн илтгэгч нараас илтгэлүүдийг авч хэвлэх ажилдаа орох юм. Өнөөдрийн хурлаар бид нийт 12 илтгэл сонссон. Нийт 9 байгууллагын төлөөлөл оролцсон байна. Яг Хятад судлалын чиглэлээр түүх болон орчин үеийн асуудлуудыг хөндсөн сонирхолтой илтгэлүүд байж чадсан гэж бодож байна. Хүрээлэнгийн зүгээс илтгэгч нартаа талархлаа илэрхийлж, ном, сэтгүүлүүдийн дээж, хуанли зэргийг бэлдсэн байгаа. Та бүхэн боломжтой үедээ ирж аваарай. Түүрүүн Р.Төрдалай докторын танилцуулсан Ч.Далай гуайн 9 ботийн Хятад судлалтай холбогдох 7 дугаар боть болон нийт 9 ботийн цахим хувийг та бүхэнд зориулж бэлтгэсэн байгаа. Үүнийг бас хүрээлэн дээр ирээд авч болно.

Доктор Д.Шүрхүү: Хятад судлалыг цааш хөгжүүлэх талаар бодлогын зөвлөмж гаргая гэж бодож байгаа. Та бүхэн саналаа ирүүлээрэй. Бид номынхоо ард ч юмуу оруулчихаж болох байх. Хурал хэзээ хийх нь тодорхойгүй байсны улмаас урьдчилаад судалгааны сэдэв, санхүүжилт, хамтын ажиллагааны хэлбэрүүд, сургалт, судалгааны арга зүй, төрөөс ямар дэмжлэг хүсмээр байна гэх мэт саналуудыг тусгаад зөвлөмж гаргачихъя гэж бодож байсан боловч амжсангүй. Эмхэтгэлийг цөөн тоогоор хэвлээд удирдах байгууллагууд, шийдвэр гаргагчдад хүргэх учраас та бүхэн саналаа ирүүлбэл их баярлах байна. Ерөнхийдөө Хятад

судлалыг бодлогын талаас, зохион байгуулалт, менежментийн талаас юу хийх вэ, яах ёстой вэ гэдэг санал санаачилгуудыг тусгахыг зорьж байгаа юм. Одоогоор 2 юм яваад байна. Тухайлбал Н.Ганбат доктор Монгол, Хятадын шинжлэх ухаан, технологийн хамтын ажиллагааны талаар дүгнэлт хийсэн байна. Энд нэг дүгнэлт гарна. Яг Хятад судлалаар гэвэл бас нэг өөр дүгнэлт санал зөвлөмж гарах байх. Та бүхэн саналаа ирүүлбэл нэгтгээд товчхон, 2 хуудсанд багтаагаад зөвлөмж гаргах саналтай байна.

Элчин сайд Г.Батсүх: Олон улсын харилцааны хүрээлэн, түүний дотор Хятад судлалын салбарынханд талархал илэрхийлж баяр хүргэе. Цаг үеэ олсон чухал хурал боллоо. Хурлаас шийдвэр гаргагчдад зориулж санал, зөвлөмж гаргах нь зүйтэй. Энэ саналыг дэмжиж байна. Цаашид ч гэсэн зохион байгуулах хурлуудынхаа мөрөөр санал, зөвлөмж гаргаж байх нь зүйтэй. Миний санал гэвэл судалгааг цаашдаа эдийн засаг, худалдаа, хөрөнгө оруулалтын харилцаан дээр нэлээд анхаарал хандуулж хийх нь чухал байна. Тухайлбал Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдал, эдийн засгийн тусгаар тогтнолд Хятад, Монголын худалдаа, эдийн засгийн харилцаа ямар үүрэг гүйцэтгэж байх вэ?, цаашид юун дээр анхаарах вэ? гэдэг дээр нарийвчилсан судалгаа хийж, төр засагт тодорхой санал зөвлөмжийг хүргүүлж байх нь зөв зүйтэй гэсэн бодол надад байдаг юм. Монгол Улсын Хятад судлалыг хөгжүүлэх нэгэн ажил бол “БНХАУ-ын эдийн засгийн хөгжлийн судалгаа” хамтын юм уу ганц сэдэвт судалгааны зохиол, хятад ёс заншил, түүх судлалаар хамтын бүтээл байх хэрэгтэй байна. Мөн Монгол Улсын эдийн засгийн аюулгүйд байдалд Монгол-Хятадын худалдааны үзүүлэх нөлөө, түүний төлөв гэсэн судалгаа чухлаар шаарддагдаж байгаа гэж бодож байна.

Энэ удаагийн хурлыг нэрт Академич, судлаач Ч.Далай агсны 90 насны ойд зориулж зохион байгуулж байгаа нь их онцлог юм. Энэ нь цаашид Хятад судлалын чиглэлийг барьж ажиллах нэрт судлаач эрдэмтдийнхээ нэр алдрыг мөнхжүүлэхэд нэгэн сайн үйл хэрэг болно гэж дүгнэж байна.

Докторант Д.Бадамцэцэг: Сайн байцгаана уу. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Миний хувьд хятад судлаач, олон улсын харилцааны мэргэжилтэн бишээ, хуульч мэргэжилтэй, багшийн ажил эрхэлдэг. Өнөөдрийн хуралд оролцсон илтгэгчид голдуу түүхч, олон улсын харилцаа судлал, Хятад судлалаар мэргэшсэн хүмүүс байх шиг байна. Аливаа харилцаа, олон улсын харилцааны үндэс нь хууль тогтоомж буюу эрх зүйн зохицуулалтууд байдаг билээ. Иймд цаашид Монгол Улс болон БНХАУ-ын хооронд байгуулсан гэрээ хэлцэл, олон улсын эрх зүйн зохицуулалт руу чиглэсэн эрдэм шинжилгээний хурал, эсвэл салбар хуралдааныг зохион байгуулбал олон улсын эрх зүйн чиглэлийн хуульч, эрдэмтэн, судлаачид оролцох байх. Хуралд илтгэл хэлэлцүүлсэн оролцогчид болон зохион байгуулагчдад баярлалаа. Хэдийгээр хятад судлаач биш ч гэсэн Хятад судлалын талаар маш их мэдээлэлтэй боллоо. Та бүхний эрдэм судлалын ажилд амжилт хүсье.

Доктор Д.Шүрхүү: Хятад судлалын хурлыг хийх гол зорилго бол хятад судлаачид хаана юу хийж байна? Ямар судлаач байна?, зөвхөн хятад хэл мэддэг,

Хятадад сурсан хүмүүс биш салбар салбарын ажиллагааг хамтран хөгжүүлэх тал дээр их анхаарч ажилласан. Мэдээллийн чанартай хэлэхэд манай хүрээлэн ирэх оны төлөвлөгөөндөө эхний хагас жилд Монгол, Хятадын нүүрсний худалдааны салбарын боломж ба сорилт гэсэн чиглэлээр зөвлөлдөх уулзалт хийхээр төлөвлөж байгаа. Дараа дараачийн уулзалтууд бол чөлөөтэй. Философийн судалгаа байж болно. Боловсролынх байж болно. Эдийн засаг, худалдаа, эрчим хүч, төмөр зам, Батсүх элчин сайдын хэлдгээр уул уурхайн салбарын судалгаа байж болно. Дан ганц 2 орны гэлтгүй, ОХУ-ыг багтаагаад 3 улсын асуудлыг хөндсөн судалгааг ч мөн оруулж болно. Энэ удаагийн хурлаар цаашдын хурлуудын агуулга, хэлбэрийг гаргаж ирэхийг бас их зорьсон. Нөгөө талаар бид бас дангаараа энэ хурлыг хийгээгүй. Гадаад харилцааны сайд биднийг хүлээн авч, судалгааны чиглэл санал тавьсан. Ялангуяа нүүрсний худалдаа, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, жонш гэх мэт олон салбарыг дурдаж болно. Иймээс бид Гадаад харилцааны яамтай хамтарч хийж байгаа юм шүү гэдгийг бас тодотгож хэлье. Бас нэг чиглэл бол Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба, Стратегийн судалгааны хүрээлэн гээд аюулгүй байдлын бүтцүүд бас байгаа. Цаашид бид тал бүрийн оролцоотой судалгааны групп болоод ажиллавал илүү үр дүнтэй байх гэж бодож байна.

Доктор Н.Алтантөгс: Хуралд оролцсондоо баяртай байна. Хурлын явцад нэг зүйлийг анхаарах хэрэгтэй юм болов уу гэж бодлоо. Энэ нь Хятад судлалынхаа хэрэглээг анхаарах. Үүний тулд Хятад судлалын бие даасан байгууллагатай болох. Ийм байгууллага байхгүй цөөхөн улсын нэг нь Монгол Улс байх. Тэгсэн мөртлөө Хятадтай хамгийн урт хуурай хилээр хиллэдэг, хамгийн эртний хөршүүдийн нэг. Гэвч Хятад судлалын бие даасан хүрээлэн ч юмуу байгууллага байдаггүй. Энд тэнд хэсэг хэсгээрээ яваад байдаг. Тухайлбал ОУХХ дотор салбар хэлбэрээр байх жишээтэй. Иймээс Хятад судлалын бие даасан хүрээлэн, судалгааны байгууллагатай болох талаар ажиллавал зүгээр юм болов уу.

Нөгөө талаас Хятад судлалыг нийгэм дэх хэрэглээ талаас нь харвал хамгийн том хэрэглэгч нь Засгийн газар юм. Тиймээс ч Хятад судлалын гол санхүүжүүлэгч нь Засгийн газар. Гэвч Хятад судлалын үндсэн асуудлууд одоогийн хөгжлийн түвшинд суурь судалгаа дээр төвлөрөөд байгаа. Ер нь Хятад хэн юм бэ? Ямар соёлтой улс вэ? Ямар түүхтэй вэ? Монгол Улстай яаж харилцаж байсан бэ гэдэг ч юмуу. Гэтэл одоо Засгийн газраас Хятад улстай харилцахад тулгамдаж байгаа асуудлууд нь жишээлбэл эдийн засгийн тусгаар тогтнолд яаж нөлөөлөх вэ? Соёлын асуудал ямар байна? Эдийн засгийн хамтын ажиллагааг яаж илүү үр дүнтэй болгох вэ? зэрэг тулгамдаж байгаа асуудлуудаар судалгаа арай бага хийгдээд байгаа юм болов уу. Тэгэхээр Хятад судлалын тэргүүлэх чиглэл, сэдвийг гаргаж ирэх, түүнийг Засгийн газраас эсвэл Гадаад харилцааны яамнаас шууд зарладаг байх. Түүндээ зориулж төсөв батлаад тэргүүлэх чиглэлийн сэдвүүдээр хийгдэж буй судалгаануудыг санхүүжүүлдэг байх ийм механизм руу шилжих санал дэвшүүлбэл ямар вэ? Жишээлбэл Хятадын таван жилийн төлөвлөгөө ба умард бүс. Эсвэл Хятад, Оросын харилцааны өнөөгийн байдал, Өвөр Монголын Өөртөө Засах Орон, эсвэл Хятадын умард болон төвийн бүс дэх нүүрсний хэрэглээ гэдэг ч юм

уу. Тулгамдаж байгаа асуудал дээр үндэслээд тодорхой сэдвүүдийг зарладаг. Түүнд үндэслээд судалгаа хийдэг болмоор байна. Энэ бол Хятадад байдаг тогтолцоо юм. Хятадад эрдэмтний сонирхлыг санхүүжүүлдэггүй. Засгийн газар нь өөрөө мөнгө гаргаж, судалгааны сэдвийг нь зааж өгдөг. Бид ийм зам руу орж байж Хятад судлал нийгэмтэйгээ нягт уялдаатай хөгжих юм болов уу гэж бодож байна.

Доктор Д.Золбоо: Өнөөдрийн хурал нь нэг салбарт ажилладаг хүмүүсийн хувьд бие биенийгээ ойлгосон, цаашдаа хийх ажлаа тодорхой болгосон, үр бүтээлтэй хурал болсон гэдэгт илтгэлтэй байна. Хуралд идэвхтэй оролцсон нийт илтгэгч нар, зохион байгуулагч нартаа, ажлын хэсгийнхэндээ талархал илэрхийлье.

Доктор Р.Төрдалай: Эрдэм шинжилгээний хурлын хэлэлцүүлэг маань амжилттай болж өндөрлөлөө. Олон чухал сэдвээр асуулт, хариулт явж анхаарч ажиллах үнэтэй саналууд гарлаа. Идэвхтэй оролцсон бүх эрдэмтэддээ баярлалаа. “Олон улс судлал 2020: Монголын Хятад судлал” эрдэм шинжилгээний хурлыг хааж, ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн захирал, доктор, дэд профессор Д.Золбоо таныг үг хэлнэ үү хэмээн хүсье.